

**“ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДӨР-2026”-Г ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Уриа: **"Хүмүүнлэг сэтгэлээр цусаа өгч амьдрал бэлэглэе!"**

Үндэслэл:

Дэлхий дахинаа жил бүрийн 6-р сарын 14-ийг хүний амь аврах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулдаг сайн дурын, авлагагүй цусны донорууддаа талархал илэрхийлэх **“Цусны Донорын Дэлхийн Өдөр”** хэмээн тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай.

Монгол Улсад бүртгэлтэй 200 гаруй мянган цусны донор байгаагаас тогтмол буюу идэвхтэй байдлаар цусаа бэлэглэдэг 40 орчим мянган сайн дурын авлагагүй донор байна. Эдгээр доноруудын хүнлэг энэрэнгүй, сайн дурын авлагагүй цус нь жирэмслэлт болон төрөлттэй холбоотой их хэмжээний цус алдалт, хүүхдийн хүнд хэлбэрийн цус багадалт, нарийн төвөгтэй мэс засал эмчилгээний үед зайлшгүй шаардлагатай байдаг. Түүнчлэн хадуур эст цус багадалт, талассеми, гемофили, дархлааны эмгэг зэрэг архаг өвчтэй хүмүүсийн урт хугацааны эмчилгээний үед амьдралын чанарыг дэмжихэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болдог. Мөн эдгээр сайн дурын цусны доноруудыг олон нийтэд сурталчлан таниулах, алдаршуулах арга хэмжээг зохион байгуулсаар ирсэн.

Иймээс аюулгүй, хүртээмжтэй цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг тогтвортой бүрдүүлэх, сайн дурын, авлагагүй цусны донорын хөдөлгөөнийг бэхжүүлэх, төрийн тогтвортой дэмжлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог өргөжүүлэх шаардлагатай хэвээр байсаар байна.

Зорилго:

ДЭМБ-аас жил бүрийн уриаг батлан гаргадаг бөгөөд энэ жил **"Хүмүүнлэг сэтгэлээр цусаа өгч амьдрал бэлэглэе!"** гэсэн уриа нь донорууд цусаа бэлэглэснээр тусламж хэрэгтэй байгаа олон хүний амьдралыг өөрчилж, ам аварагч болохыг онцолж байна. Тогтмол хугацаанд цусаа бэлэглэдэг доноруудыг урамшуулах, эрүүл хүмүүс түүний дотор залуучуудыг цусаа бэлэглэн цусны донор болохын ашиг тус, эрүүл зөв амьдралын хэв маягт уриалан дуудах зорилготой.

2026 оны арга хэмжээний зорилтууд:

1. Дэлхий даяар байнгын, сайн дурын, авлагагүй цусны донорын хөдөлгөөнийг тогтвортой өргөжүүлэх;
2. Аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээ, ач холбогдлын талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх;

3. Шинэ доноруудыг урамшуулах, оролцоог нэмэгдүүлэх;
4. Цусны доноруудын эрүүл мэнд, нийгэмд оруулж буй хувь нэмрийг алдаршуулах;
5. Эв нэгдэл, хүнлэг энэрэнгүй чанар, хамтын хариуцлагын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх;
6. Аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ, тэгш хүртээмжтэй байдлыг хангах үндэсний хөтөлбөрүүдийг дэмжихэд төр болон төрийн бус байгууллагууд бусад түншүүдийн оролцоог нэмэгдүүлэх

Санхүүжүүлэгч байгууллага:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага – 10.2 сая
2. Цус сэлбэлт судлалын үндэсний төв – 5 сая
3. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэн

Хэрэгжүүлэгч байгууллага:

1. Эрүүл мэндийн яам
2. Цус сэлбэлт судлалын үндэсний төв
3. Цусны салбар төв
4. Монголын Улаан загалмай нийгэмлэг
5. Монголын донорын холбоо ТББ

Хугацаа:

2026 оны 06 дугаар сарын 14

Гарах үр дүн:

- ДЭМБ-ын хэрэгжүүлж буй ЦДДӨ-ийн уриа, удирдамжийн хэрэгжилт хангагдана.
- Цусны донорын талаарх сургалт сурталчилгааны мэдээллийн бааз нэмэгдэнэ.
- Хүн амын дунд цусны донорын талаарх мэдлэг, хандлага сайжирна.
- Цус цусан бүтээгдэхүүний байнгын нөөцийг бүрдүүлэхэд тодорхой нөлөө үзүүлнэ.

ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДӨР-2026"-ийн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Уриа: "Хүмүүнлэг сэтгэлээр цусаа өгч, амьдрал бэлэглэе!"

Хугацаа: 2026.06.14

Хугацаа	Үйл ажиллагаа
08:30	Зочидыг бүртгэх
Урлагийн мэндчилгээ нээлт	
09:00	Хүндэт Зочдыг танилцуулна
09:15	Нээлт: "Хүмүүнлэг сэтгэлээр цусаа өгч, амьдрал бэлэглэе!" уриан дор тэмдэглэнэ. ЦССҮТ-ийн захирал, АУ-ны доктор Б.Нарантуяа нээж үг хэлнэ
09:25	ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр мэндчилгээ дэвшүүлнэ
09:35	ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч мэндчилгээ дэвшүүлнэ
Урлагийн мэндчилгээ	
09:40	Шагнал гардуулах арга хэмжээ
Урлагийн мэндчилгээ	
10:00	МУЗН-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга Н.Болормаа мэндчилгээ дэвшүүлнэ
10:05	Монголын Донорын холбооны мэндчилгээ дэвшүүлнэ
10:30	Шагнал гардуулах үйл ажиллагаа үргэлжилнэ.
Урлагийн мэндчилгээ	
10:35	Хүндэт доноруудад шагнал гардуулах арга хэмжээ
11:15	Цусны донорын тухай хуулийг батлуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан хүндэт зочидод хүндэтгэл үзүүлнэ.
11:25	Монгол Улсын хамгийн олон удаа цус цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн ТОП донорт хүндэтгэл үзүүлэх
11:30	Хүмүүнлэгийн үйлсийг дэмжигч шилдэг байгууллага Сүү ХК Монголын Донорын холбоо ТББ-ын ахмад донор элсүүлэгч, угтах үйлчилгээний ахмад ажилтан нарт өөрийн бүтээгдэхүүний дээжээр баярын мэндчилгээ дэвшүүлнэ
11:40	МУЗН-ийн Нэрэмжит шагнал гардуулах арга хэмжээ
12:00	Нэгдсэн зураг авалт
Урлагийн мэндчилгээ	
12:15	Хаалт "Хүмүүнлэг сэтгэлээр цусаа өгч, амьдрал бэлэглэе!"